

## Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 11 дүгээр сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт




#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 11 дүгээр сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 546 болж, 2013 оны мөн үеэс 913 хүнээр, өмнөх сарынхаас 228 хүнээр тус тус буурав.

Ажилгүйчүүдийн 50,37 хувь буюу 275 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 2085 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 1474 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 41,11 хувь буюу 606 нь эмэгтэйчүүд юм.

Зураг I.1

#### Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 11 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 251 ажилгүй иргэний 31,9 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан; 21,9 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 13,9 хувь нь нэмэлт чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 8,8 хувь нь өөр газраас шилжин ирсэн; 8,0 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 4,0 хувь нь орон тооны цомхтголд орсон; 2,4 хувь нь гүйцэтгэж буй ажил албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 2,0 хувь нь байгууллага татан буугдсан; 1,2 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих; 0,4 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0,4 хувь нь цэргээс халагдсан; 0,4

хувь нь хорих газраас суллагдсан; 0,4 хувь нь тэтгэвэрт гарсан; 4,4 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 4,6% нь дээд; 16,7% нь тусгай дунд; 46,7% нь мэргэжлийн анхан шатны; 8,6% нь бүрэн дунд; 5,3% нь бүрэн бус дунд боловсролтой; 18,1% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

#### Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



### I.2 Нийгмийн даатгал, халамж

#### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 11 сард НДШ-ийн орлого 10.02 тэрбум ₮ болж төлөвлөгөө 84.82 хувь болж, төлөвлөгөөг Борнуур сум 2.24 хувиар давуулан биелүүлж, бусад сум 7.48-20.55 хувиар тасалдууллаа. Сайндурьн НДШ-ийн орлого 456.9 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 1.60-30.95 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 28.6тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 230900₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 45.80% хувийг орлогоороо үрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 34.9%; тэтгэмжийн даатгалын сангийн 92.9%; эрүүл мэндийн даатгалын сангийн 89.0%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 284.5%; ажилгүйдлийн даатгалын сангийн 76.6%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 11 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 49850 хүнд олгож, 9.0 тэрбум ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 17.17 хувь 10339 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 45.16 хувь 2.8 тэрбум ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 105910 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.75 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 27.93 хувийг халамжийн тэтгэвэр; 11.03 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.94 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.39 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.94 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 1.19 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




### 1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 11 сард 14236 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.9 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 11 сард 1229 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 92 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 11-р сард нялхсын эндэгдэл 18 гарч өмнөх оны мөн үеэс 4-өөр өссөн байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд 1 хүүхэд гарсан ба өмнөх онд 1 хүүхэд буюу ижил байна.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар




2014 оны эхний 11сард нийт гарсан халдварт өвчнөөр 462 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 31.14 хувь буюу 209 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 1.9 дахин, заг хүйтэн 1.5

дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 52байгаа бол: Сүмбэр 141, Зуунмод 138, Сэргэлэн 59, Батсүмбэр 57 ногдлоо.

Зураг I.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар



I.4 Байгаль орчин

### Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Төв аймгийн 2014 оны 11-р сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур -6-12 градус хүйтэн, ихэнх нутаг, Дэлгэрхаан, Заамар орчмоор дулаан, нутгийн зүүн болон өмнөд хэсэг, Мөнгөнморьтод хамгийн хүйтэн байв.

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь +6,0+13,0 градус дулаан, нутгийн зүүн болон зарим газраар хүйтэн, Мөнгөнморьт орчмоор хиймгийн хүйтэн, баруун өмнөд хэсгээр дулаавтар, Лүн, Бүрэн, Заамар, Дэлгэрхаан, Жаргалант, Баян-Өнжүүл, Борнуур орчмоор 11,0-13,0 градус дулаан байв.

-шөнийн хугацааны хамгийн бага температур нь -22-29 градус хүйтэн буюу

нутгийн баруун хойд хэсгээр буюу Лүн, Заамар орчмоор дулаан, нутгийн зүүн хэсэг, томоохон голын хөндий дагуух нутгууд буюу Өндөрширээтэд 29 градус хүрч хүйтэрлээ.

- тунадас 0,0-8,9 мм, нутгийн зүүн болон өмнөд хэсгээр бага 0,0-0,8 мм буюу ороогүй, нутгийн баруун хэсгээр арай ахиу буюу хамгийн их нь Жаргалантад 8,9 мм, Батсүмбэрт 5,2 мм, цас орж,одоогийн байдлаар 0-7 см зузаан цастай байна. / өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр /

- Салхи ихэнх хугацаанд баруунаас 4-9 м/с, цас орох үеэр зарим газраар 7-12 м/с, зарим газраар 16-18 м/с, түр зуур 20-24 м/с хүрч ширүүслээ. Аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи багатай, харин 2-3 удаа ихэнх нутгаар цас орж шуурсан байна.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

Цаг агаарын үзүүлэлтүүдийг 2013 оны 11-р сартай харьцуулахад:

2014 оны 11-р сарын цаг агаарын

үзүүлэлтүүдийг 2013 оны 11-р сартай харьцуулахад:

-агаарын дундаж температур ихэнх нутгаар 1-3 градусаар хүйтэн буюу ойролцоо

-өдрийн хамгийн их температур нь ихэнх нутгаар 1-3 градус орчмоор дулаан буюу ойролцоо

-шөнийн хамгийн бага температур өмнөх оноос ихэнх нутгаар 1-5 градусаар хүйтэн буюу ойролцоо байна.

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд ихэнх нутгаар / Жаргалант,

Заамараас бусад / өмнөх 11-р сараас 0,1-6,5 мм-ээр бага цас оржээ.

- Сарын ихэнх өдрүүдэд өмнөх оноос нийт нутгаар хүйтний эрч сулавтар, цас багатай байгаа ч, цаашид дээрх нутгуудаар цасны зузаан улам нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлөхөөр байна. Мөн сарын эцсээр үе үе хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаанд хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

#### 2014 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь уулархаг нутгаар 22-27 градус, баруун өмнөд хэсгээр 10-15 градус, бусад нутгаар 16-21 градус хүйтэн байх ба дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй.

Хүйтний эрч сулрах үе: Нэгдүгээр арав хоногийн эх болон сүүлчээр хүйтний эрч суларч Туул голын хөндийгөөр шөнөдөө 19-24 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 14-19 градус, өдөртөө 5-10 градус хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч өдөртөө бага зэрэг суларч Туул голын хөндийгөөр 11-16 градус, бусад нутгаар 7-12 градус хүйтэн байна.

Хүйтрэх үе: Харин гуравдугаар арав хоногийн эхээр хүйтний эрч чангарч, ялангуяа дунд үеэс Туул голын хөндийгөөр шөнөдөө 35-40 градус, өдөртөө 22-27 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 27-32 градус, өдөртөө 16-21 градус хүйтэн байна.

Бусад хугацаанд: Туул голын хөндийгөөр шөнөдөө 25-30 градус, өдөртөө 15-20 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 22-27 градус, өдөртөө 11-16 градус хүйтэн байна.

Энэ сард Төв аймгийн зүүн хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунжийн орчим цас орох төлөвтэй.

Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар цас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орох төлөвтэй.

Салхи нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар 12-14 м/с хүртэл ширүүсч цасан шуурга шуурна.

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

12 дугаар сарын цаг агаарын мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджаас дулаан, Увс, Завхан, Ховд, Говь-Алтайн хил залгаа сумдын нутаг, Өмнөговийн зүүн, Дорнод, Сүхбаатар, Дорноговийн өмнөд хэсгээр дунжийн орчим байх ба цас ихэнх нутгаар олон жилийн дунжийн орчим ба түүнээс ахиу, харин Баян-Өлгийн хойд хэсэг, Завхан, Архангай, Баянхонгор, Говь-Алтайн хил залгаа сумдын нутаг болон Алтайн өвөр говиор олон жилийн дунджаас бага орох төлөвтэй байна.

Одоогийн байдлаар нутгийн 30 гаруй хувьд 0-9 см зузаантай цасан бүрхүүл тогтоод байна. 12 дугаар сард цасны зузаан нэмэгдэж, нягтарч хатууран мал өвөлжилтөнд таагүй нөлөөлж болзошгүй байна. Мөн үе үе хүчтэй цасан шуурга шуурч малын хариулга маллагаанд

хүндрэл учруулж болзошгүй онцгой анхаарна уу.

### 2014 ОНЫ АРВАН ХОЁРДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Төвийн нутаг Энэ сарын агаарын температурын дундаж нь Туул голын хөндийгөөр 25-30, Төв аймгийн баруун өмнөд хэсгээр 11-16, бусад нутгаар 18-23 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард Төв аймгийн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар дунджаас ахиу цас орох төлөвтэй.




#### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 11 сард аймгийн хэмжээнд 904 гэмт хэрэг бүртгэгдэж 774 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 2.7 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 11 дүгээр байдлаар



Гарсан гэмт хэргийн 43.81 хувь нь хулгай, 25.00 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 11.73 хувь нь бусад хэрэг. 15.27 хувь нь замын осол, 3.10 хувь нь танхай дээрэм, 1.11 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Аргалант, Баянхангай, Баян, сумдад 10000 хүнд 402-115 гэмт хэрэг ноогдсон нь аймгийн дунджаас (102)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 40 хэргээр өслөө.

Зуунмод суманд 40 эмэгтэй, 1002 эрэгтэй нийт 1042 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 165 хүнээр буурлаа.


Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, тэр-бум төгрөгөөр





## Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 11 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 1361 гүйцэтгэх хуудсанд нийт 4.11 тэрбум₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 515 гүйцэтгэх хуудсанд ногдох 1.07 тэрбум₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 846 гүйцэтгэх хуудасны 3.03 тэрбум₮-өөс 484 хуудасны 2.2 тэрбум₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудсны тоогоор 57.21 хувь, үнийн дүнгээр 72.24 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 9.23 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 36.37 нэгжээр тус тус өслөө.



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

Иргэдийн хувийн хадгаламжинд 11 сарын 30-ний байдлаар 38.4 тэрбум ₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 11 сарын 30-ний байдлаар 117.5 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 26.5 тэрбум ₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 121.9 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Харилцах дансны үлдэгдэл 11 сарын 30-ны байдлаар 262699 иргэний 10.8 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.35 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.70 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.58 хувьтай байна.



### II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2014 оны эхний 11 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 10.9 тэрбум ₮, зарлага 57.0 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 120.28 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: ХХОАТ, Бууны албан татвар, газрыг төлбөр, Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамжийн төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 22.47 хувь буюу 2.0 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 84.15 хувийг татварын, 15.46 хувийг татварын бус, 0.39 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2013 оны мөн үеэс татварын орлого 3.08 нэгжээр өсч, татварын бус орлого 2.35 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.73 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 15.3 тэрбум ₮ болж аймгийнх 8.8 тэрбум ₮ буюу 57.91 хувь, сумынх 2.0 тэрбум ₮ буюу

13.28 хувь, улсынх 4.4 тэрбум ₮ буюу 28.82 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 2.91 хувь буюу 17.9 сая ₮-өөр буурч 596.3 сая ₮, авлага 2.63 хувь буюу 3.1 сая ₮-өөр өсч 118.6 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 10.3 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 122.08 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 2.0 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 214.86 хувь биелж, Эрдэнэ, Угтаал, Алтанбулаг 17.23-12.86 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 8.8 тэрбум ₮ болж 109.26 хувь биелж, Баянжаргалан, Сүмбэр, Борнуур, Жаргалант, Цээл, Өндөрширээт, Угтаал, Баянхангай, Эрдэнэсант, Мөнгөнморьт, Дэлгэрхаан, Батсүмбэр, Баян-Өнжүүл, Лүн, Бүрэн сумд 56.44-0.43 хувиар тасалдууллаа.



### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ


2014 оны 11 дүгээр сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үеболох 2010 оны 12 дугаар сараас 50,87%, өмнөх оны мөн үеэс 9,62%, өмнөх сараас 0,73 хувиар тус тус өсөв.

11 дүгээр сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин зэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 25,33%; сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 2,34%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 2,27%, талх гурил, будааны дэд бүлгийн үнэ 1,42%-аар тус тус өслөө. Жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 7,24%; төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ 2,37%; саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ

1,68%; мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,14%-аар тус тус буурч согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ тогтвортой байв.

Зураг II.4

### Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 11 дүгээр сарын 0,73 хувийн өсөлтийн гол шалтгаан нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнийн өсөлт байлаа.

Зураг II.5

### Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бүгд	2014 оны 11-р сард	
	пунктээр	хувиар
Бараа, үйлчилгээний бүлэг	0.73	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.36	49.79%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.33	45.38%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.00	0.00%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.03	3.81%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗӨЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	1.02%



### II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 11 сард 13.07 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн


үетэй харьцуулахад 2.25 дахин буюу буюу 9.06 тэрбум₮-өөр өсөв.

Барилга угсралт их засварын ажлын 10.0 хувь нь орон сууцны барилгад; 24.4 хувь нь орон сууцны бус барилгад; 65.6 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдлоо. Энэ нь 2013 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 24.2 пунктээр буурч; орон сууцны барилгын ажил 0,7 пунктээр; инженерийн барилга байгууламжийн ажил 23.5 пунктээр тус тус өссөн үзүүлэлт юм.

Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 18 хүнээр буурч, цалингийн сан 189,1 сая₮-өөр өсөв.

Зураг II.8

**Барилгынажлынгүйцэтгэл, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр**



**II.7 Холбоо**

Холбоо ашиглалтын орлого оны эхний 11 сард 255.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 128.6 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 4.1 хувь буюу 10.2 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 18.8 сая ₮ болж, нийт орлогын 79.9 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 19.91 хувийг албан бичгийн, 11.86 хувийг

зорчигчдийн, 68.22 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10  
Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 11 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр

